



**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2023 оны ээлжит 09 дүгээр хуралдааны  
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 09 дүгээр хуралдааныг 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 09 дүгээр хуралдаанаар “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2022 оны 38 тоот тогтоол); “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2020 оны 71 тоот тогтоол); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт); “ХХЗХ-ны хуралдааны дэг”-ийг шинэчлэн батлах тухай нийтдээ 6 асуудлыг тус тус хэлэлцэн зохицуулах хорооны 6 тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 тоот тогтоол, уг тогтоолын хавсралтаар “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг баталж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2022 оны 09 дугаар 23-ны өдрийн 5949 дугаарт бүртгүүлэн хүчин төгөлдөр мөрдөн хэрэгжүүлж байна. Энэхүү баримт бичиг нь Монгол улсын нутаг дэвсгэрт радио давтамж ашиглан FM радиогийн үйлчилгээ эрхлэхдээ ашиглах радио давтамжийн зурвасыг хуваарилах, түүнд ашиглах техникийн нөхцөл, шаардлагыг тодорхойлсон юм. Зөвшөөрлийн тухай хууль батлагдан 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчлагдсан. Тус хуулийн 1 дүгээр бүлгийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт үндэслэн зөвшөөрөл олгох сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тогтоосон захиргааны актыг хүчингүй болгож, нарийвчилсан хуулиар зохицуулах болсон. Үүнтэй холбоотой Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.6-д заасан бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил харилцаа холбооны сайдын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/42 дугаар тушаалын хавсралтаар “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийг баталж, хүснэгтэд сонгон шалгаруулалтаар олгох радио давтамжийн зурвасыг шинэчлэн тодорхойлоод байна. Хүснэгтийн 4 дэх цараа VHF буюу хэт богино долгионы зурвас (30-300 МГц)-ийн 76-87.5 МГц-ийн зурвасын ашиглалтыг “өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад ашиглана”, тусгай нөхцөлд “FM радиогийн өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах үйлчилгээнд сонгон шалгаруулах журмаар олгоно” гэж тус тус зааж өгсөн болно. Харилцаа холбооны зохицуулах хороо нь Радио долгионы тухай хуулийн 51.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд FM радиогийн өргөн нэвтрүүлэгт ашиглах зурваст өөрчлөлт орсон тул тус хорооны 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага” захиргааны актад “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-д өөрчлөлт орсонтой холбоотойгоор доорх нэмэлт, өөрчлөлтийг оруулан төслийг боловсруулан Захиргааны ерөнхий хуулийн

дагуу цахим хуудас, эрх ашиг нь хөндөгдөж байгаа хуулийн этгээд, оролцогч талуудад хэлэлцүүлэн саналыг тусгасан болно. Зохицуулах хорооны 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит 09 дүгээр хуралдаанд Радио давтамж зохицуулалт, хяналтын газраас “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай танилцуулга, шийдвэрийн төсөл, тогтоолын хавсралт, холбогдох уулзалт хэлэлцүүлэг, саналыг тусгасан товчоо судалгаа, хуулийн нөлөөллийн шинжилгээг зэрэг баримт бичгийг боловсруулан хэлэлцүүлсэн болно. Тус хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Хорооны 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 88 тоот “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолыг хавсралтын хамт батлав. Уг тогтоолоор, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 2 дугаар зүйлийн 2.11, 2.12 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3, 4.4 дэх хэсэгт холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тус тус оруулав. Энэхүү тогтоолыг хавсралтын хамт ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан хөдөлгөөн хийлгэж бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын албан тоотоор хүргүүлээд байна.

ХХЗХ-ны 2020 оны 71 тоот тогтоолоор “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г тогтоож баталж, энэхүү тогтоолыг ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5272 дугаарт бүртгүүлэн хүчин төгөлдөр мөрдөж байна. Ажлын хэсгээс Хорооны 2023 оны ээлжит 08 дугаар хуралдаанд “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-нд өөрчлөлт оруулах тухай танилцуулга, уулзалт хэлэлцүүлэг болон албан тоотоор ирүүлсэн санал, эрх ашиг нь хөндөгдөж байгаа нэр бүхий 7 компанийн удирдлагатай ажлын хэсгийн хийсэн уулзалтын үр дүн, саналын товчооны танилцуулгыг сонсож, тус хуралдаанаас эрх ашиг нь хөндөгдөж байгаа ААН, хуулийн этгээд нартай уулзалт зохион байгуулах, Даргын зөвлөлийн хуралдаанд дахин хэлэлцүүлэх, баримт бичгийн төслийг Дараагийн Хорооны хуралдаанд хэлэлцүүлэх, батлуулах арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсэгт даалгасан билээ. Энэхүү хорооны хуралдаанаар өгсөн чиглэл, үүргийг хэрэгжүүлэх зорилгоор 2023 ээлжит 09 дүгээр хуралдаанд хуралдаанд “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай танилцуулга, тогтоолын төсөл, нэмэлт өөрчлөлт оруулах саналын төсөл, уулзалт хэлэлцүүлэг, ирүүлсэн, хэлэлцүүлгийн саналыг тусгасан саналын товчоо, хуулийн нөлөөллийн шинжилгээг зэрэг баримт бичгийг дахин хэлэлцүүлэв. Тус хорооны хуралдаанаас “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-нд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийн төсөл нь энэхүү баримт бичгийг шинэчлэн батлах төслийн хэмжээнд хүрсэн гэж үзээд, шинэчлэн батлах төслийг боловсруулах, эрх ашиг нь хөндөгдөж байгаа үйлчилгээ эрхлэгч нартай уулзалт зохион байгуулах, шинэчилсэн баримт бичгийн төслийг албан тоотоор хүргүүлэх, улмаар Хорооны дараагийн хуралдаанд хэлэлцүүлэхийг ажлын хэсэг, ЗЗҮТЗГ /Д.Ариунболд/, РДЗХГ /З.Амгалан/-т тус тус чиглэл болгов.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 09 дүгээр хуралдаанаар тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) газар хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт

бүхий 4 тогтоол, хавсралтын төслийг тус тус авч хэлэлцээд, тус хуралдаанаас 4 тогтоолыг хавсралтын хамт баталсан. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 89 тоот тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдэд 4 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 90 тоот тогтоолын хавсралтаар 7 хуулийн этгээдийн 7 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.12.2 дахь заалт, 14.12.3 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 91 тоот тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрлийг 45 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт, Радио долгионы тухай 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.8 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалт, Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Сайдын 2023 оны 42 дугаар тушаалын хавсралтаар баталсан Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 92 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэсэн.

Харилцаа холбооны салбарын бие даасан зохицуулах хороог байгуулахаар 2001 оны 10 дугаар сард хуульчилж, Засгийн газрын 2002 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар тогтоолын хавсралтаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийг анх баталсан. Уг дүрмийн хүрээнд “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг анх 2002 оны 01 тоот тогтоолын хавсралтаар баталжээ. Улмаар энэхүү хуралдааны дэг баримт бичигт 2007 оны 14 тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж, 2010 оны 27 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Тус хорооны 2010 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-д 2013 оны 31 тоот тогтоол, 2015 оны 54 дүгээр тогтоол, 2016 оны 14 тоот тогтоолын хавсралтаар тус тус холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулан хүчин төгөлдөр мөрдөж байсан болно. Монгол Улсын Засгийн газрын “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм шинэчлэн батлах тухай” 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тогтоолын хавсралтаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийг шинэчлэн баталж, 2016 оны 43 тоот тогтоолын хавсралтаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг шинэчлэн баталж байжээ.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 03 дугаар хуралдаанд “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал, танилцуулгыг Хорооны даргаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /ХХНБ-ийн дарга/ Т.Наранмандахаас боловсруулан хэлэлцүүлсэн бөгөөд тус хуралдаанаас Хорооны гишүүн А.Лувсан-Очир, Хуулийн хэлтсийн дарга Т.Ууганбат, ХХНБ-ийн дарга Т.Наранмандах нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийн байгуулан ажиллуулахаар тогтож, хуралдааны дэгийн асуудлыг

боловсруулан 2023 оны эхний хагаст багтаан хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг даалгасан болно. Ажлын хэсгээс “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг шинэчлэн батлах төслийг боловсруулахдаа хорооны бүрэн эрх, чиг үүрэг нэмэгдсэн, хууль эрх зүйн шинэ орчин бүрэлдэн бий болсон, хорооны хуралдаанд гишүүд биечлэн оролцох харилцааг хэрэгжүүлэх, сард нэгээс доошгүй удаа хуралдаанд заавал биечлэн оролцох (ХХЗХ-ны дүрэм, Заалт 3.2.4); Хорооны хуралдаанд гишүүдийн цахим оролцооны зохицуулалт, цагийн урамшуулалтай уялдуулах, хуралдааныг зохион байгуулахад цаасгүй технологи, технологийн ололтыг ашиглах, нууцлалтыг хангах; хорооны хуралдаанд асуудал хэлэлцүүлэх үйл ажиллагаанд ажлын албадын удирдлага, бүх шатны ажилтнуудын үүрэг, хариуцлагын асуудлыг нарийвчлан тусгах; хорооны хуралдааныг зохион байгуулах, шийдвэр гаргах, албажуулах, баримтжуулах процесс, зохицуулалтын харилцаа зэрэг асуудлыг судлан тусгаж, “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг шинэчлэн батлах тухай танилцуулга, тогтоолын төсөл, хавсралтын хамт боловсруулан хорооны Хорооны 2023 оны ээлжит 08 дугаар (2023-07-04) хуралдаанд танилцуулсан. Уг хуралдаанаас энэхүү асуудлыг Хорооны дараагийн ээлжит хуралдаанаар баримт бичгийг хэлэлцэн батлуулах, хорооны гишүүдэд урьдчилан хүргүүлэхийг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга, Ажлын хэсэгт үүрэг даалгавар болгосон юм. Энэхүү үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор ажлын хэсгээс Зохицуулах хорооны 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит 09 дүгээр хуралдаанд “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг шинэчлэн батлах тухай танилцуулга, тогтоолын төсөл, тогтоолын хавсралт бичгийн төсөл, саналын товчоог эцэслэн боловсруулан хэлэлцүүлсэн ба Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 4 дүгээр зүйлийг үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 93 тоот “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг шинэчлэн батлах тухай тогтоолыг хавсралтын хамт баталж, тогтоолыг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр шийдвэрлэв. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2019 оны 28 дугаар тогтоол, 2021 оны 19 дүгээр тогтоол, 2022 оны 62 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгов. Энэхүү дэгийг Хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга болон нийт ажилтан, албан хаагчид хэлбэрэлтгүй дагаж мөрдөнө. Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааныг Засгийн газрын 2016 оны 268 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм” болон энэхүү батлагдсан хуралдааны дэгийн дагуу зохион байгуулна. Хорооны дарга, гишүүд нь хуралдаанд оролцох, тогтоол батлах, мэдээлэл, танилцуулга сонсох, тэмдэглэл гаргах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаандаа Хорооны дүрмийн 3.1-3.2-д заасан Хорооны дарга, гишүүдийн бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэхэд энэхүү дэгийг баримтална.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо  
2023-08-01